

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 – 31

1. Нэг.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

5 – 31

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны 06 дугаар сарын 26-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 01 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганмаа, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга;

Чөлөөтэй: Х.Баттулга;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Ганбаатар, С.Замира;

Тасалсан: Ж.Батсуурь, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Үндэсний аудитын газрын Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа, мөн газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Д.Энхдалай, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Мөнхцэцэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч Б.Цагаанцэцэг, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баяр-Эрдэнэ, Төрийн сангийн газрын Санхүүжилтийн тайлан, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Т.Сайхантөгс, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуй, бодлого зохицуулалтын газрын Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Э.Батболд, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр гүйцэтгэгч П.Зохихсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Т.Бадрахбаяр, мөн яамны Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, мөн газрын

шинжээч, ерөнхий нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс, Татварын ерөнхий газрын Татвар хураалт, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Л.Зулцэцэг, референт Г.Нямсүрэн, С.Уянга, Б.Батцэцэг, ажилтан Д.Оюун, У.Наранбуян нар байлцав.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, О.Саранчулуун, Б.Пунсалмаа, О.Батнайрамдал нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр гүйцэтгэгч П.Зохихсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Т.Бадрахбаяр, мөн яамны Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 57 минут үргэлжилж, 21 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр 16 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
16 цаг 01 минут

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Монгол Улсын Их Хурлын 2026 оны 6 сарын 26-ны өдрийн Өргөдлийн байнгын хорооны хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул 2026 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, Ж.Золжаргал гишүүн, Д.Рэгдэл гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Х.Жангабыл гишүүн, М.Сарнай гишүүн, Ж.Галбадрах гишүүн, Чинбатын Ундрам гишүүн, Ц.Мөнхтуяа гишүүн, О.Номинчимэг нар ирсэн байна.

Нийт ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хувьд өмнөх хуралдаан бас ирц хүрээгүйн улмаас хойшлогдсон. Тэгэхээр даргын дэргэдэх зөвлөлөөс баталсан хэлэлцэх асуудалд 3 асуудал туссан байгаа.

Нэгдүгээрт, Өргөдлийн байнгын хороо Засгийн газар, яам, агентлагт шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын мэдээлэл сонсох.

Хоёрдугаарт, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн биелэлтийн талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын

сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн мэдээлэл сонсох.

Гуравдугаарт, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу санал, дүгнэлттэй Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэхээр заасан. Энэ гурван асуудал байна.

Өнөөдөр бид чуулганы үеэр хугацаатай асуудал байгаа учраас өмнө нь товлогдсон эхний хоёр асуудал буюу Өргөдөл гомдлын шийдвэрлэлт болон хот суурины ус хангамж ариутгах татуургатай холбоотой иргэдийн өргөдлийг хасах саналтай. Дараагийн хуралдааны товд оруулж хасах саналтай.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл хэлэлцэх санал гишүүдээс гарч байгаа. Тэгэхээр энэ дээр горимын санал гаргаж байна.

Тэгэхээр зөвхөн өнөөдөр 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан хэлцэх хуулийн хугацаатай тул Байнгын хорооны хэлэлцэх асуудлын нэг дэх, хоёрдугаарт хэлэлцэх асуудлыг хойшлуулаад гурав дахь асуудлыг хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна. Горимын саналын санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Хэлэлцэх асуудлын нэг, хоёрдугаар асуудлыг хойшлуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орьё. Хэлэлцэх асуудал.

**Нэг.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл,
Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон
“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**
/Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, **хоёр дахь хэлэлцүүлэг,**
санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна.

Сангийн сайд З.Мэндсайханы микрофоныг өгье.

З.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн боловсруулж, “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт Засгийн газраас 2026 оны 6 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30 их наяд 303.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 33.7 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.8 хувьд тус тус хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьтай тэнцэж байна.

Тайлан онд улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 18 их наяд 988 тэрбум төгрөгт хүрч 95.9 хувийн биелэлттэй, нийт зарлага, цэвэр зээлийн дүн 20 их наяд 414.3 тэрбум төгрөг буюу 90.5 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 613 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 2 их наяд 135.4 тэрбум төгрөгийн буюу 73 хувийн санхүүжилтийг гадаадын зээл, тусламжийн хүрээнд 116 төсөл, арга хэмжээнд 1 их наяд 874.9 тэрбум төгрөгийн буюу 96 хувийн санхүүжилтийг нийт 729 төсөл, арга хэмжээнд 4 их наяд 10.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, энэ хүрээнд 1800 орчим аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж ажилласаар 110 мянган ажлын байрыг хэвээр хадгалж, улсын хэмжээнд 490 төсөл, барилга байгууламж ашиглалтад орлоо.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 8.10.2 дахь заалтад тус тус заасны дагуу нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийлгэн, улсын төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг баталгаажуулсан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарлын төсөлд баярлалаа.

О.Номинчимэг: Сангийн сайд Загджавын Мэндсайхан танд баярлалаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. 3 номерын микрофон нээе.

С.Магнайсүрэн: Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн талаар хураангуйлан танилцуулъя.

Нэг.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл хийсэн аудитын талаар.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл төсвийн тухай хуулийн дагуу аудитыг гүйцэтгэж, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30 их наяд 303.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөгөөр баталгаажууллаа.

Төсөв захирагчдын шилэн дансны шилэн дансны хөтлөлт 94.2 хувь, харин улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээ, хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа хуулийн этгээдүүд мэдээллийг ил тод, бүрэн байршуулаагүй, гүйцэтгэл хангалтгүй байна.

Улс төрийн намуудад олгосон төрийн санхүүжилтийн зарцуулалтын зардлын ангилал, шалгуур үзүүлэлт тодорхойгүй, хууль, журмын заалт уялдаагүй, хяналт шалгалт хийх чиг үүрэг давхардаж байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах нэгдсэн дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлсэн 611 төсөл, арга хэмжээний 80 хувь буюу 6 их наяд 981.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 415 төсөл нь боловсрол, зам тээвэр, хот байгуулалт, эрүүл мэнд, эрчим хүч гэсэн тэргүүлэх 5 чиглэлд төвлөрсөн нь суурь дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг хүртээмжийг бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэжээ.

2.Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын тухайн жилийн санхүүжилтийн гүйцэтгэл 72.9 хувь. Тухайн онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 75.1 хувьтай байгаа бөгөөд барилга

байгууламжийн хоёр ажил тутмын нэг нь ТЭЗҮ, зураг төсөл боловсруулалт, 5 ажил тутмын 4 нь тухайн онд хэрэгжиж дуусаагүй дараагийн онд шилжсэн байна.

3.Улсын төсвийн хөрөнгө оруулалт төсөвт өртгийн 80 хувийг эзэлж байгаа голлох 5 салбарын төсвийн ерөнхийлөн захирагчдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг төлөвлөсөн шалгуур үзүүлэлтээр нь авч үзэхэд дунджаар 77.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд 23 сургууль ашиглалтад орж, суралцагчдын тоо нь 10.6 мянгаар, 20 цэцэрлэг ашиглалтад орж, хамрагдах хүүхдийн тоо 3 мянгаар, 2 дотуур байр ашиглалтад орж, орны тоо 280-аар, соёлын төв, театрын 8 барилга баригдаж, суудлын тоо 2.3 мянгаар, 10 эмнэлгийн барилга ашиглалтад орсноор эмчлүүлэгчдийн орны тоо 154-өөр тус тус нэмэгджээ.

Мөн инженерийн дэд бүтцийн 36, дэд станц болон цахилгаан хангамжийг сайжруулах 30 байгууламж ашиглалтад орж, хатуу хучилттай авто зам 330.3 километрээр, гүүрний хүчин чадал 282 урт метрээр тус тус нэмэгдсэн зэрэг нийгмийн үйлчилгээ болон суурь дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ахиц гарсан байна.

Дээрх дүгнэлтдээ үндэслэн төсвийн үр ашгийг дээшлүүлэх, гадаадын зээл, тусламж, ашиглалт, үр нөлөөг сайжруулах, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлагыг хангуулж, эдийн засгийн ангиллыг мөрдөх, худалдан авах ажиллагааг хууль журамд нийцүүлж, барилга байгууламжийн чанар, ашиглагдаж буй материалд эрүүл ахуй, стандартын шаардлага тавих, хяналтын тогтолцоог сайжруулах зэрэг арга хэмжээнд чиглэгдсэн нийт 35 зөвлөмжийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлээд байна.

Хоёр.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын талаар.

Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нийгмийн болон Эрүүл мэндийн даатгалын сан болон төсвийн ерөнхийлөн захирагчдын 60 санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа байгууллагуудын нийт 6792 санхүүгийн тайланг аудитад хамрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 32, хязгаарлалттай 28 дүгнэлт өгсөн бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Төрийн аудитын байгууллагаас өмнөх жилүүдэд Засгийн газар бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдан гарч байгаа тул Их Хурлаас аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах асуудлаар Засгийн газарт чиглэл

хүргүүлж, төсвийн сахилга батыг дээшлүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай гэж үзлээ.

1.Түүхий эдийн мөчлөг сөрсөн төсвийн тэлэлтийг хязгаарласан орлогын бүтцийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлэхгүйгээр экспортын биет хэмжээнд найдсан төсвийн төлөвлөлт хийсээр байгаа нь нийлүүлэлтээс шалтгаалсан түүхий эдийн үнэ буурах, төсвийн орлого хуваарийн дагуу бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.

2.Ирээдүй өв сангийн корпорац байгуулах, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх олгосон мандатыг боловсруулж түүхий эдийн мөчлөгийн үед бий болсон орлогыг хуримтлуулах замаар төсвийн тэлэлтийг хязгаарлах бодлого хэрэгжүүлэх орон зайг бий болгох, гадаад валютын нөөцийг тогтворжуулах бодлого баримтлах.

3.Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг төсвийн төлөвлөлтийн үр дүнд чиглүүлэхээр зохицуулсан боловч тухайн жилийн төсвийн тухай хуулиар хөтөлбөр арга хэмжээг зардалтай уялдуулан батлаагүй суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлоогүй, хэмжигдэхүйц бус төлөвлөснөөс хэрэгжилтийг үнэлэх үр дүнд суурилсан төлөвлөлтөд шилжих боломжийг хязгаарлаж байна.

4.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, үр дүнг үнэлэх үе шат бүрд төсвийн ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлага сул, хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

5.Гадаадын дамжуулан зээлүүлсэн, олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй, тооцоо нийлж баталгаажаагүй авлагын асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу үе шатаа шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээрх дүгнэлтээс үзвэл төсвийн хөрөнгө төрийн өмчийн санхүүгийн удирдлагыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэхэд аудитын зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хариуцлага тооцох тогтолцоонд дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны дарга,

Эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын 2025 оны төсвийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хийсэн.

Аудитын талаар товчлон танилцууллаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

О.Номинчимэг: Монгол Улсын ерөнхий аудитор С.Магнайсүрэнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сангийн сайд Загджавын Мэндсайхан, Монгол Улсын ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Бат-Ирээдүйн Анар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Намжилын Эрдэнэбаяр, Үндэсний аудитын газраас Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга Хоржавын Баярмаа, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ганболдын Нандинжаргал, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Доржсүрэнгийн Энхдалай,

Эрүүл мэндийн яамнаас Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Лхагважавын Мөнхцэцэг,

Сангийн яамнаас Санхүүгийн бодлогын газрын дарга Солонгын Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Нарангийн Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох, Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч Болдбаатарын Цагаанцэцэг, Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Баясгалангийн Баяр-Эрдэнэ, Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Мэндээгийн Алтанхорол, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Тайванжаргалын Сайхантөгс нар оролцож байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас Нийтийн аж ахуй, бодлого зохицуулалтын газрын Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Эрдэнэбатын Батболд,

Боловсролын яамнаас Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Эрдэнэ-Очирын Адьяасүрэн, Боловсролын зээлийн сангийн ажлын албаны дарга үүрэг гүйцэтгэгч Пүрэвсүрэнгийн Зохихсүрэн,

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Жамбалын Энхтөр, Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах дарга, шинжээч, ерөнхий нягтлан бодогч Цэвэгдоржийн Эрдэнэтөгс,

Татварын ерөнхий газраас Татвар хураалт арга зүйн газрын дарга Рэгзэнгийн Мягмаржав нар оролцож байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ бүртгүүлнэ үү.

4 гишүүнээр тасаллаа. /алх цохив/

Ирцийн дарааллаар Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би хоёрхон л юм асууя.

Сая С.Магнайсүрэн дарга ч бас өөрөө хэллээ. Экспортын борлуулалтад суурилсан төсөв гэж. Төсвийн тэлэлттэй холбоотой асуудлуудыг хөндсөн.

Энэ Үндэсний аудитын газар бүрэн эрхийг нь яг яаж илүү чадамжтай болгох вэ? Яагаад гэхээр жил болгон ийм дүгнэлт гардаг.

- Сөрөг,
- хязгаарлалттай,
- дүгнэлтгүй гээд л яваад байдаг.

Холбогдох албан тушаалтнуудад Үндэсний аудитын газар маань хариуцлага тооцож чадахгүй байгаа.

Тэгээд би үүнийг Үндэсний аудитын газар гэхээс илүү Улсын Их Хурлын гишүүдийг их сайн ойлгож аваасай, хараасай гэж хүсээд байгаа юм. Яагаад гэхээр хэдүүлээ нийлж байж энэ Үндэсний аудитын газрын бүрэн эрхийг чадамжтай холбоотой асуудлыг хөндөж, хуульд нь өөрчлөлт оруулж бас нэг тодорхой илүү боломжийг нь олгохгүй бол Үндэсний аудитын газар яг өөрсдийнхөө түвшинд бол ажиллаад байгаа юм.

- Зөрчил,
- хийдэл,
- хууль зөрчсөн асуудлуудыг гаргаж тавиад байгаа.

Тэгээд хүргэж байгаа зөвлөмж, дүгнэлтүүд нь ёстой нохой ч олж тоохгүй байна л даа. Яагаад гэвэл эд нар шууд арга хэмжээ авах бүрэн эрх нь байдаггүйтэй холбоотой асуудал гэж би ойлгоод байдаг юм.

Энэ чадамжийг сайжруулах тал дээр Улсын Их Хурлын гишүүд маань бас бодоосой. Хэдүүлээ ер нь нийлж байгаад энэ дээр намрын чуулганд нэг арга хэмжээ авах нь зөв болов уу гэж би бодож байна

Хоёрдугаарт, өчигдөр төрийн өмчит компаниудын захирлуудын холбоотой асуудал сошиал даяар явлаа. Үүнийг яг үнэн эсэхийг нь хэлээд өгөөч ээ.

Үнэхээр нэг захирал сарын 64.9 сая төгрөгөө аваад байгаа юм байгаа юм уу? Мэдээж ажлаа сайн хийгээд явж байгаа бол үгүйсгэх аргагүй. Гэхдээ үүний ард ямар хэмжээний ажлын бүтээмжийг бид ингэж үнэлдэг юм бэ гэдэг асуулт байна.

Энэ гадаадын төслүүд үнэндээ замарч байна. Хөвсгөл аймагт хэрэгжиж байгаа “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл” гэж байгаа. Нэг сайд очоод туслахаа тавьсан. Нөгөөдөх нь хоёр жил самарлаа. Тэнд Монгол Улсын зээл төлдөг хэлбэр тэнд явж байгаа.

Төслүүдийг ер нь Үндэсний аудитын газар гадаадын ийм тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх гэдэг ч юм уу, иймэрхүү төслүүдийг ер нь Үндэсний аудитын газар яг нарийн ширийн шалгаж, асуудал нь хаанаа байгаа вэ гэдгийг бүрэн тодорхойлж чадаж байгаа юу гэдэг дээр би асуулт асууя. Баярлалаа.

Ч.Ундрам: Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн хариулъя. 3 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар С.Магнайсүрэн.

Үндэсний аудитын газрын тухайд Төрийн аудитын тухай хуулиар Үндсэн хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсны дараа шинэчлэн баталсан нэлээн сайн агуулгатай боломжийн хууль байдаг.

Олон улсын аудитын дээд байгууллагаас манай хуулийг нэлээн үнэлдэг. Бид ч гэсэн ажиллах эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж ойлгодог. Мэдээж ажил хийх явцад зарим сайжруулах зүйлүүд байгаа. Энэ тал дээр бид саналаа боловсруулаад явж байгаа.

Бидний тухайд ажлаа бүрэн хийх бололцоотой байна. Гол асуудал бол аудитын шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой асуудал нэлээн яригдаж байгаа юм.

Бид “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар” гээд тусдаа зохион байгуулалтын бүтцийн нэгж бий болгосон. Өмнө нь орхигдсон байсан бүх датагаа

нэгтгэж базаад хэрэгжсэн, хэрэгжээгүйгээр нь ялгаад, тэгээд нэлээн ажиллагаа явж байгаа.

Тухайлах юм бол бид төрд учруулсан хохирлын асуудлаар 7.2 тэрбум төгрөг өнөөдрийг хүртэл төлөгдөөгүй байгаа.

Энэ бол үндсэндээ төсөв захирагч нар буюу дарга нарын гаргасан шийдвэр байдаг. Энэ бүрэн бололцоотой асуудал учраас Улсын ерөнхий прокурортой хамтраад энэ асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэхээр улсын прокурор төр төлөөлөх, төрийн эрх ашгийг хамгаалах субъектийнхээ хувьд шүүхэд асуудлууд тавиад ингээд бид бас боломжийнхоо хүрээнд ажиллаад эхэлсэн байгаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой бид онцгойлон анхаараад явж байгаа.

Яах вэ, зарим томоохон асуудлууд, бодлогын хэмжээний асуудал нэг жилд шийдэгдэх боломжгүй асуудал байдаг.

Тухайлах юм бол Ерөнхий сайдад өгсөн төрийн өмчит компанитай холбоотой асуудлаар өгсөн зөвлөмж бол өнөөдөр бид үнэлээд 50 хувьтай гэж үзэж байгаа. Яагаад вэ гэвэл өнөөдөр Их Хурал дээр энэ хуулийн төсөл нь яваад батлагдсаны дараа л бид үүнийг бүрэн биелсэн гэж үзнэ үү гэхээс биш манай зөвлөмж 50 хувьтай байна гээд л явж байгаа.

Ер нь харьцангуй үр дүн гарч байгаа гэж ойлгож болно. Хариуцлагын асуудлыг бид сайжруулаад явж байгаа. Өнгөрсөн жилээс зөрчил 11.9 хувиар буурсан. Тоон дүн нь өртгийн дүн буюу мөнгөн дүн жоохон ихтэй байгаа. Гэхдээ ерөнхий давтамжийн тоо бол буурсан.

Өнөөдөр бид ерөнхийдөө хууль хяналтын байгууллагад яг 2025 оны санхүүгийн тайлангийн дүнгээр 18 асуудал хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. 252 хариуцлага тооцуулах албан тоот холбогдох газруудад явуулсан.

Үүнээс гадна төсвийн хуулийн 70 дугаар зүйлд заасан “албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно”, “хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” гэсэн заалтуудын хүрээнд бид 53 төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд 2300 алдаа, зөрчлийг нь ялгаад, 70.1 дээр танай харьяа байгууллагууд ийм зөрчил гаргалаа. 70.3 дээр нь ингэлээ, 4 дээр нь ингэлээ, 5 дээр нь ингэлээ гээд бүгдийг нь ялгаад явуулж байгаа.

Дөнгөж сая аудит 6 сарын 15-нд тайлан нэгдэхдээ л бид ялгаж салгаад явуулж байгаа. Жишээлбэл, хамгийн өндөр тоо Боловсролын сайд дээр бид 752 субъект буюу байгууллагын зөрчлийн асуудлыг явуулсан.

Тэгээд тэрний дараа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам гэх мэтчилэн өндөр тоотой байна.

Ингээд бид ирэх долоо хоногоос авхуулаад өндөр тоотой зөрчилтэй салбарын төсвийн ерөнхийлөн захирагчдын хүрээнд хэлэлцүүлгүүд буюу уулзалтууд зохион байгуулж, үүнийг хэрхэн яаж шийдэх вэ, цаашдаа яаж зөрчлийг багасгах вэ гэдэг ийм асуудлуудыг ярихаар хуваарь гарсан явж байна.

Саяын энэ төрийн өмчит компаниудын захирлуудын цалинтай холбоотой асуудлыг би товчхон хэлэхэд –

- ▷ **Нэгдүгээрт**, төсвийн зарлагыг яаж багасгах вэ, орлого яаж нэмэгдүүлэх вэ гэдэг асуудлаар судалгаа, тооцоо хийдэг ийм чиглэл Улсын Их Хурлын шинэ удирдлагаас өгөгдсөний дагуу хийсэн.
- ▷ **Хоёрдугаарт**, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос энэ чиглэлээр тусгайлсан судалгаанууд гаргаж танилцуулах үүрэг авсны дагуу бид хийсэн байгаа.

О.Номинчимэг: Хариулт гүйцээе. 3 номер.

С.Магнайсүрэн: Гарсан үр дүнг сая Зарлагын хяналтын дэд хороонд өгөөд энэ асуудал одоо ингээд олон нийтэд нээлттэй болж байх шиг байна.

Ер нь 64.9 сая гэдэг сарын цалин биш. Үүнийг би Төсвийн зарлагын хяналтын дэд хороон даргад бас тайлбарлаж хэлсэн. Энэ бол тухайн ондоо ерөөсөө тухайн гүйцэтгэх удирдлагад ногдсон буюу тийм хөрөнгийн дүн байгаа.

Энэ дотор –

- хоол унаа нь орж байгаа,
- жилийн эцэст авдаг бүтээмжээсээ шалтгаалаад контракт гэрээнийхээ дагуу авч байгаа урамшууллууд орж байгаа,
- цалин нь орж байгаа.

Ингээд бүх зүйл нь ороод тэр гараад ирсэн дүнг нь 12 сард нь хуваахаар ийм дүнтэй ногдож байна л гэсэн дүгнэлт хийж бид өгсөн.

Зүгээр яах вэ, цалингийн асуудлыг би шууд хэлэх нь хаашаа юм. Гэхдээ энэ яригдаж байгаагаас хоёр дахин доогуур үндсэн цалин нь бол тийм. Нэрлэсэн цалин нь тийм юм билээ.

Тэгээд бүтээмж, ажлынхаа үр дүнгээс урамшуулал... /минут дуусав/

О.Номинчимэг: 3 номер дахиад 1 минут гүйцээж хариулъя. 2 номер.

Д.Энхболд: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад үргэлжлүүлээд хариулъя.

Үндэсний аудитын газар Д.Энхболд.

Гадаадын зээл, тусламжийн хөтөлбөрүүдэд аудит хийдэг үү гэж асуусан.

Тэгэхээр Үндэсний аудитын газраас санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитыг хийж байгаа.

Санхүүгийн аудитаар 2025 онд нийтдээ 116 төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайланд аудит хийж, нийт 40 дүгнэлт гаргаснаас –

- өөрчлөлтгүй 23 дүгнэлт,
- хязгаарлалттай 17 дүгнэлт,
- 70 төсөл, хөтөлбөрийг аудитад хамруулан үзсэн байгаа.

Төсвийн шууд захирагч гэдэг утгаар нь төсөл, хөтөлбөр бүр дээр.

2021 болон 2025 онд гадаадын зээл, тусламжийн хөтөлбөрүүдийн үр дүнг гүйцэтгэлийн аудит хийгээд мөн тайланг Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байгаа.

О.Номинчимэг: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. С.Магнайсүрэн дарга өөрийнхөө амаар хэллээ шүү. Ажиллах эрх зүйн орчин бол бүрэн бүрдсэн, сэтгэл хангалуун байгаа гэдгийг.

Тэгэхээр аливаа асуудал үүсвэл бид Та бүхэнтэй ярина.

Гадаадын төсөл, хөтөлбөртэй холбоотой асуудал дээр санхүүгийнх нь хувьд тайлан хийгээд байдаг. Наад хүмүүс чинь ажлаа хийхгүй байна шүү дээ. Хөвсгөл аймгийн Хатгалаас Тойлогтын чиглэлд хийгдэж байгаа 37.9 километр зам 2 жил наад хүмүүс чинь ажлаа хийсэнгүй шүү дээ.

Бас ажил хийхгүй байгаа юм чинь санхүү нь яах вэ дээ. Тэнд компани хохироод байдаг, иргэд хохироод байдаг асуудал байгаа байхгүй юу. Та бүхэн зөвхөн санхүүгийн аудит яриад байна.

Нөгөө талдаа 64.9 сая төгрөгтэй холбоотой асуудал дээр хоол унаа, контракт, урамшуулал, бусад зардлууд бүгд багтдаг гэдэг зүйлийг сая хариуллаа. Үүнийг нь задалж Та нар тодорхой хэмжээнд дотор талд нь үздэг юм уу? Энэ дээр алдаа дутагдал байна уу?

О.Номинчимэг: 3 номер.

С.Магнайсүрэн: Манай шинэ бүтцээр бид өгөгдлийн дата анализ хийдэг багуудтай.

Үүнийг хийж байж бид бодлогын зөвлөмж, шийдлүүдээ гаргах шаардлагатай. Дээр нь Их Хурлаа ч гэсэн мэдээллээр хангах бололцоотой болж байгаа.

Энэ жил эхний ажил нь 10-аад төрлийн судалгаа хийсэн.

Төрийн өмчит компани цахим программд зарж байгаа мөнгө, хурал, зөвлөгөөн, семинар, гадаад томилолт гэх мэтчилэн.

Тэгэхээр энэ бол сая таны ярьснаар ойлгож болно. Бид баланс дээр нь гүйцэтгэх удирдлагад нь ногдож байгаа цалин, урамшуулалтай адилтгах орлого, зардал гэдгээс гэдгийн л 12 сард хуваагдаад ногдол нь ингэж ногдож байна гэдэг байдлаар тавьсан. Нарийвчлаад мэдээлэл авна гэвэл Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр болоод бусад газар байж байгаа.

Түрүүний таны хэлдэгтэй холбогдуулаад одоо энэ төсвийн гүйцэтгэл, санхүү, хүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцдэг энэ процессыг нэлээн сайжруулах шаардлага байна гэж үзээд зарим Байнгын хороодоос бидэнд Сангийн яамтай хамтраад юм боловсруулж 9 сарын 1 гэхэд... /минут дуусав/

О.Номинчимэг: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Намайг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байхад Байгаль орчны яаман дээр 24 төсөл 170 сая доллар орчим байсан.

Гадаадын энэ хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн аудит яг хийгддэг үү гэдэг дээр хийгддэг гэж хариулсан.

Би ч өөрөө хийлгүүлж байсан. Үүний үр дүн хангалтгүй байгаад байгаа дээр л асуудлууд байгаад байгаа юм л гэдгийг би хэлээд байгаа юм.

Тийм учраас Та бүхэн өөрсдөө хууль эрх зүйн орчин дээр асуудал байна уу?

Та бүхний хүргүүлсэн зөвлөмж гэдэг юм уу, үр дүн хүрэхгүй байгаа юм биш биз дээ?

Өнгөрсөн 2024, 2025 онд Байгаль орчны яам тэгвэл ямар дүгнэлт авсан бэ?

Хязгаарлалттай дүгнэлт аваад сайжрах ёстой. Холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох ёстой. Тийм ээ. Сөрөг дүгнэлт авсан бол хариуцлага тооцох ёстой, сайжрах ёстой.

Тэр үйл ажиллагаа. Тэгвэл Байгаль орчны яам 2024, 2025 онд ямар дүгнэлт авсан бэ?

Хэдэн гадаадын төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа вэ?

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? 3 номер уу? Хаана вэ? Тийшээ микрофон дээр суух уу? 3 номер. С.Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Товчхон хариулъя.

Гаднын зээл, тусламжтай холбоотой бид хийдэг. Өнгөрсөн жилүүдийн манай зөвлөмжийн дагуу Сангийн яаман дээр зохион байгуулалт хийгээд, тухайн тухай асуудал болгон дээр байсан олон тийм төслийн нэгжүүд байсныг бүгдийг нь татан буулгаад, тухайн яаман дээр нэг л нэгдсэн тийм төсөлтэй болгоод.

–Нэгдүгээрт, зардал хэмнэсэн.

–Хоёрдугаарт, тодорхой болсон.

Манайхан энэ жилийн дүгнэлт дээр гаднын зээл, тусламж дээр хэрэгжиж байгаа энэ төсөл, хөтөлбөрийн зөрчил ихэссэн байна. Энэ дээр онцгойлон анхаараач гэж үзсэн.

Хоёрдугаарт нь, энэ хөрөнгийг эргээд үр ашигтай зүйлд зарцуулаач гэдэг санал байгаа.

Дээр нь төслийн үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэж, хүлээж авах, ашиглах асуудал их муу байна. Зарим газрууд авахгүй байна. Орон нутаг нь авахгүй байна. Хүлээж авахгүйгээс болоод олон асуудлууд байна гэдэг юмыг бид их дэлгэрэнгүй гаргаж тавьсан байгаа.

Байгаль орчинтой холбоотой асуудлаар энэ жил бол 2025 оны... /минут дуусав/

О.Номинчимэг: Сөрөг дүгнэлт авсан гэнэ. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Боловсролын хүртээмжтэй холбоотой асуултыг асуумаар байгаа.

→ Энэ жил элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулахад ямар төсөв

гаргасан бэ? Ямар зардлаар?

- Тэр дотор хэдэн хүүхэд элсэлтийн ерөнхий шалгалтанд хамрагдсан юм?
- Энэ дундаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хэдэн хүүхэд орсон бэ?
- Элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах зардал дотор хүртээмжийн тохиргоог ямаршуу зардлаар хаана яаж хийсэн бэ?

Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь, дээд боловсрол эзэмшиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо болон дээд сургуулиудын хүртээмжийн шинэчлэл ямаршуу түвшинд явж байгаа вэ?

Яагаад гэвэл бид мэдэж байгаа. Тийм ээ. 6 төрийн өмчийн гэж нэрлэгддэг сургуулиуд маань хүртээмжгүй байгаад байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар ахиц гарсан? Үүнийг би жил хагасын өмнө Боловсролын сайдад бичиг хүргүүлж энэ дээр анхаарна уу гэж ярьж байсан байгаа.

Тэгэхээр энэ дээр одоо ямар ямар их дээд сургууль хүртээмжтэй, сайжирсан юм? Юу юугаа сайжруулсан юм гэдэг дээр мэдээлэл өгмөөр байгаа юм.

Гуравдугаар асуулт нь, хөдөлмөрийн эрүүл аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ ээ гэсэн байгаа.

Тэгээд шалгуур үзүүлэлт нь ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол гэсэн юм байна л даа. Осол нь 2025 оны зорилтот түвшин 380 гэж тооцсон чинь хүрсэн түвшин 809. Ослыг бууруулах ёстой гэдэг зорилго тавьсан чинь осол нь хоёр дахин нэмэгдсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ер нь ямар арга хэмжээ авах юм бэ?

Энэ чинь өөрөөр хэлбэл энэ 809 хүнээс хэдэн хүн нь өнөөдөр насан туршийн хөгжлийн бэрхшээлтэй болсон бол оо? Энэ дээр арга хэмжээ авах хэрэгтэй.

Яагаад гэвэл энэ дээр бараг 152 тэрбум төгрөгийн зардал багцаар явж байгаа байхгүй юу. Үүнийг тодруулах хэрэгтэй байгаа.

Дараа нь Нийгмийн халамжийн кодоор байгаа энэ 71.902, 31.2.1 дээр байна л даа олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан сэтгэл ханамжийн түвшин гэнэ ээ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ юу өгдөг юм? Ямар ямар төрлийн үйлчилгээ байдгийг нэрлээд, тэгээд сэтгэл ханамжийг нь үнэлэх ёстой юм уу, тэр үйлчилгээнийхээ үр дүнг үнэлэх ёстой юм уу? Энэ дээр нэг тайлбар өгөөч. Баярлалаа.

О.Номинчимэг: Боловсролын яам, Нийгэм хамгааллын яам. Микрофон дээр очоорой. Асуулт асууж байхад холбогдох хүмүүс нь микрофон дээр хурдан очоод цагаа хэмнэмээр байна.

4 номерын микрофоныг нээе. Нэрээ хэлээд О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Э.Адъяасүрэн: Боловсролын яамны санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн. О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Энэ жилийн элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулахад нийтдээ 2.2 тэрбум төгрөгийн төсөв Боловсролын сайдын тушаалаар батлагдсан.

Яг одоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэхтэй холбоотойгоор яг тусгайлан гаргасан юу байхгүй байна. Нийтдээ даалгавар боловсруулах, тэгээд тоног төхөөрөмжтэй холбоотой 80 сая төгрөгийн төсөв байна.

Энэ дээр яг нөгөө тохируулгат орчин бүрдүүлэхтэй холбоотой төсвийг тусгайлан одоогийн байдлаар гаргасан зүйл байхгүй байна.

Их, дээд сургуулиудын орчин бүрдүүлэхтэй холбоотой асуудлыг би хариулж мэдэхгүй байна.

О.Номинчимэг: Дараагийн асуулт. Нийгмийн хамгааллын яам уу? Хаана байна? Хурдлаарай манайхан. 4 номерын микрофон. Нэрээ хэлээд асуултад хариулъя.

Т.Бадрахбаяр: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Хөдөлмөр халамжийн үйлчилгээ ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Т.Бадрахбаяр байна.

Олон нийтийн оролцогчийн халамжийн үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан зорилтот бүлгийн иргэд хамрагддаг.

Нэгдүгээрт, хөгжлийн бэрхээлт бэрхшээлтэй иргэд, ахмад настан, нийгмийн дэмжлэг, тусламж зайлшгүй шаардлагатай өрх, иргэн. Дээр нь мөн

хорих ангиас суллагдсан нийгэмшүүлэх шаардлагатай архи, тамхи, мансууруулах бодисын хамааралтай ийм иргэдэд чиглэсэн 14 төрлийн үйлчилгээ үзүүлдэг.

Олон нийтийн оролцоонд хүрсэн халамжийн үйлчилгээнд –

- 2024 онд 7100 иргэнд 2.9 тэрбум төгрөгийг,
- 2025 онд 9100 иргэнд 3 тэрбум төгрөг зарцуулсан байна.

О.Номинчимэг: Боловсролын яамнаас өөр хэн байгаа юм? О.Саранчулуун гишүүний асуултад бүрэн хариулт өгье. Элсэлтийн ерөнхий шалгалтанд хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орсон бэ гээд тодорхой асуулт асуусан байна.

4 номерын микрофон. Нэрээ хэлээд хариул.

Ж.Энхтөр: Өдрийн мэнд хүргэе.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Ж.Энхтөр.

О.Саранчулуун гишүүний асуусан үйлдвэрлэлийн ослоос хэдэн хүн хөгжлийн бэрхшээлтэй болсон гээд асуусан. Үүнийг нарийвчилсан тоог гаргаж байгаа.

2025 онд нийт 809 хүн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод орж, үүнээс 73 хүн нас барж, 736 хүн гэмтэж бэртэж, хордлогод өртсөн байна гэсэн ийм дүн гарсан байгаа.

О.Номинчимэг: Нийгмийн хамгааллын яамнаас сая тэр хорих ангиас суллагдсан хүмүүст 14 төрлийн нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлж төсөв зарцуулдаг гэсэн мэдээллээ албан ёсоор бичгээр Байнгын хороонд ирүүлэхийг хүсье.

Отгоны Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Элсэлтийн ерөнхий шалгалт дээр өнгөрсөн жил ярьсан шүү дээ. ЭЕШ-ынхаа шалгалт авах процессоо хүртээмжтэй болгох юм бол хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхдүүд бол дээд сургуулийн сурах орчин болох гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр зардал төсөвлөө гээд Боловсролын яаман дээр бид уулзаад өмнө нь ярьж байсан л санагдаад байх юм.

Тэгээд тэрнийх нь зардал байхгүй. Хэдэн хүүхэд элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн тоо байхгүй байна гэдэг чинь юу гэсэн үг юм.

Хоёрт гэвэл энэ олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг сэтгэл ханамж гэдгээр дүгнээд байх юм. Зөндөө олон тэрбум төгрөг зарцуулчихаад. Хүмүүсийг “амьдралд гаргах хөтөлбөр” гэж байгаа бол “хэдэн хүн амьдралд биеэ даасан” гэдэг үр дүн гарах ёстой шүү дээ.

Яагаад шалгуур үзүүлэлт болон энэ өгч байгаа тайлан чинь ингээд болохгүй байгаа юм?

Тэгээд одоо бид үүнийг хэдэн удаа хэлэлцээд, тэгээд одоо юу өөрчлөх юм? Ингээд дахин дахин үүнийг чинь яриад байхаар дараа жил нь сайжирч орж ирдэггүй юм уу?

Тэр элсэлтийн ерөнхий шалгалтанд хэдэн хүүхэд шалгалт өгсөн тоо гаргаадах л даа. Хэдэн хүүхэд дээд сургуульд орох юм? Дээд сургууль нь бэлэн юм уу гэдэг мэдээлэл хэрэгтэй байна шүү дээ.

О.Номинчимэг: Боловсролын яам, Нийгмийн хамгааллын яам. Энэ шалгуур үзүүлэлтүүдээ буруу тодорхойлсон асуудал байгаад байгаа юм байна. Тийм үү.

2025 оны юун дээр. Үүнийгээ тайлбарлаад, засаж залруулж байгаа зүйл байгаа юу? Энэ төсвийн гүйцэтгэлийн бас тайлагнах хэлбэр дээр анхаарах ёстой юмнууд байна гээд Улсын Их Хурлын гишүүд ярьж байгаа. Тийм. Тэгэхгүй бол яг ийм шахуу хугацаанд 6 сард нэг ийм том юм орж ирчхээд, цаасан хэлбэртэй. Тийм ээ. Эсвэл PDF файл.

Тэгээд энэ бүгдийг яг ингээд цаг гаргаад анализ хийж суухад бол тун хүндрэлтэй байгаа. Тийм ээ?

Тэгэхээр бид нарын бас төсвийн гүйцэтгэл хэлэлцэх процесс, арга барил ч гэсэн цаашид өөрчлөгдөх ёстой. Түүн дээр шийдлүүд яригдаж байгаа гэдгийг бол хэлье. 4 номер.

Т.Бадрахбаяр: Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар.

Би түрүүн хэлсэн. 14 төрлийн үйлчилгээг үзүүлэхдээ бид аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийг сонгон шалгаруулж тендерийн хуулийн дагуу сонгон шалгаруулдаг. Тухайн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдээ нэг бүрчлэн сэтгэл ханамжийн судалгаанд хамруулдаг.

Энэ судалгаагаа төрийн бус байгууллагууд тайландаа тусгаж, тайлан дээр тэр үйлчилгээ авч байгаа иргэдийн сэтгэл ханамжаар гүйцэтгэлийг гаргадаг юм.

О.Номинчимэг: Отгоны Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Одоо тэгээд сэтгэл ханамжаа ярьсаар байгаад одоо 10 жил болж байна шүү дээ. Бараг 20 жил ч юм уу.

Энэ олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээн дээр би 2017 онд мониторингийн нөхцөлөөр ажиллаж байсан юм.

Яг үүнийгээ яриад л, тэгээд л үр дүнг нь болохоор яг хүн амьдрал дээрээ гарсан юм уу, бие даасан гэдэг үр дүн байхгүй. Сэтгэл ханамж гэдэг нэг асуултаар өнөөдөр ямар байна, сэтгэлд таалагдаж байна уу, үгүй юу гэдэг хаалттай асуултаар хэдэн юм асуучхаад, тэгээд тэрийгээ улсын төсөвт зарцуулалтын тайлан гээд гаргаж оруулж ирээд байх юм. Бүгдээрээ үүнийгээ больё л доо.

Хоёр жил энэ нэг улсын төсвийн тайлан, төлөвлөгөө сонсоод шалгуур нь болохгүй байна гэж ярилаа шүү дээ. Яамны чинь ажлыг өмнөөс чинь өчнөөн л хийлээ шүү дээ.

Битгий ийм юм оруулаад бай л даа. Тэгээд одоо үүнийг чинь сайжруулах юм уу, үгүй юу. Би ерөөсөө ойлгохгүй байгаад байна. Улсын мөнгө зараад тэр халамж хүндээ очихгүй байгаа чинь тэр шүү дээ.

Сэтгэл ханамжаар юу илэрхийлэх гээд байгаа юм бэ? Энэ чинь динамик шинжтэй тухайн моментийн л үзэгдэл шүү дээ. Амьдралын бодит үр дүнгийн юм оруулж ир л дээ.

О.Номинчимэг: Үг хэлэв үү? Үг, байр суурь илэрхийллээ. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? 2025 онд Өргөдлийн байнгын хороо байгуулагдсан байгаа.

Тэгээд ямартай ч иргэд маань өргөдөл, гомдлоо Өргөдлийн байнгын хороон дээр ирүүлдэг болсон байгаа.

Тэгэхээр одоо хэлэлцэж байгаа асуудал нь болохоор 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын нэгдсэн тайлан хэлэлцэж байгаа юм.

Тэгэхээр яг энэ төсөв, санхүү, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, иргэдийн амьжиргаатай холбоотой ер нь хэр их санал, гомдол Өргөдлийн байнгын хороон дээр ирэв ээ? Энэ тал дээр Үндэсний аудитын газар ер нь ямар дүгнэлт гаргаж байна аа?

Хоёрдугаарт нь, иргэдийн ирүүлж байгаа санал, гомдол маань улсын төсөв, жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүд дээр ер нь хэрхэн сууж байгаа юм бэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь, сая улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тавигдах зарим арга хэмжээний талаар тогтоолын төсөл батлагдсан. Энэ дагуу 2025 онд жишээлбэл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд дотор төсөвт өртөг нь нэмэгдсэн хэчнээн төсвүүд байв.

Түүнээс Үндэсний аудитын газар дүгнэлтээ гаргаад хэдэн төсөлд арга хэмжээ нэмэгдэхээс хамгаалж. Тийм ээ. Түүнийг бууруулж чадсан бэ гэдэг асуудал.

Гуравдугаарт нь, Үндэсний аудитын газар өөрсдөө энэ төсөв, санхүүтэй холбогдолтой маш их дүгнэлт гаргаж байгаа. Энэ дүгнэлтийн үр дүн, хэрэгжилт ямар байдаг юм бэ? Жишээлбэл, Эрчим хүчний яаман дээр Та бүхэн минь дүгнэлт гаргасан байсан. Тэр дүгнэлт сайн байсан. Гэвч эрчим хүч түрүү жил тасалдсан. Өвөл бараг хөлдөх дээрээ тулсан. Хэрвээ Та бүхэн шүдтэй арслан гэдэг шиг илүү хүчтэй сайн ажилласан байсан бол магадгүй үүнийг таслан зогсоох боломж байсан уу?

Цаашдаа ер нь Та бүгдийн үйл ажиллагааг сайжруулж, Та бүгдийн дүгнэлтийг ажил болгох ямар хууль эрх зүйн орчин танай салбарт хэрэгтэй байгаа юм гэдэг ийм гурван асуултыг асууя.

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? 3 номер. Ерөнхий аудитор С.Магнайсүрэн.

С.Магнайсүрэн: Б.Пунсалмаа гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар С.Магнайсүрэн.

Би хууль эрх зүйн орчноос нь эхлээд хариулъя. Хөрөнгө оруулалтаар нь манай Д.Энхболд дарга.

Хууль эрх зүйн орчны тухайд одоо ингээд хамгийн сүүлд Өргөдлийн байнгын хороогоор хэлэлцэгдэж байна.

Өмнөх байнгын хороо дээр яригдсан асуудал ч тэр, ер нь энэ гүйцэтгэлийг л нэлээн сайн ярьж байгаа юм. Төсвийг бараг 2 сар гаруй ярилцаад баталдаг. Гүйцэтгэлийн нэг, хоёр долоо хоногт их бага ярьж байна гээд. Их тийм цаг бага байна гэдэг дээр хаана хаанаа санал нийлж байгаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт дээр Авлигатай тэмцэх газар манай хоёр биелэлт гаргаад, тэгээд энэ дээр би манай хоёр нэг ярьж байгаа тохирсон санал юу вэ гэхээр зэрэг гүйцэтгэлийг ер нь төсөв захирагч болгоноор нь юм уу, шууд төсвийн ерөнхийлөн захирагч нараар нь юм уу тулж дагнаж ярьж.

Манайд өнөөдөр Улсын Их Хуралд төсвийн хяналтын сонсгол хийх хууль эрх зүйн орчин нь байж байгаа. Энэ хүрээгээ ашигладаг юм уу, үгүй бол цаглаварт хугацаагаа нааш цааш хөдөлгөж. Одоо бид чинь 6 сарын 10-нд өгдөг л хуультай. Түүндээ арай гэж шөнө, өдөргүй сууж байгаад л өгч байгаа.

Тэгээд хаврын чуулганаар хэлэлцэж баталдаг хуультай учраас ингээд л яалт ч үгүй ингэж шахагдаж явж байгаа. Энэ чиглэл дээр өөрчлөлт оруулах нь зүйтэй байна. Ийм үүрэг чиглэл өмнөх Байнгын хороодоос өгөгдсөн. 9 сарын 01 гэхэд Сангийн яам, танай хоёр энэ юмаа нэг санал оруулж ирээч ээ гэсэн.

Энэ тал дээр бид угаасаа бид нарын санал тийм байгаа учраас бид энэ дээрээ санал оруулж ирнэ гэж ойлгож болно.

Хөрөнгө оруулалттай холбоотой. Ер нь иргэдийн өргөдөл, гомдолтой холбоотой асуудал бол хөрөнгө оруулалттай нэлээн холбогддог. Дээр нь тодорхой сэдвүүд нэлээн ирдэг.

Тэгэхээр бид ирэх нэг дэх өдөр Төсвийн байнгын хороогоор 2027 онд хийх сэдвээ оруулж ирж байгаа юм.

Тэгээд бид эрт оруулж ирж эрт төлөвлөхгүй болдоггүй.

Тийм учраас энэ дээр иргэдийн хамгийн их санал авсан, хамгийн их хүсэн хүлээж байгаа гэдгээр нь эрэмбэлж 4, 5 шалгуураар эрэмбэлдэг. Үүний нэгэн дээр нь иргэдийн санал гол асуудал байдаг.

Тэгээд энэ эрэмбээрээ шалгарсан бид арван хэдэн ийм сэдэв аваад ингээд орж ирж байгаа. Энэ дотор жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал орсон явж байх жишээтэй. Ингээд бид нэг дэх өдөр үүнийгээ ярина.

Тэгэхээр иргэдийн өргөдөл, гомдолд бид яг ийм маягаар энэ сэдвээрээ нэг яана. Тухайн аудиттай холбоотой гомдол, санал байвал түүнд нь асуудлыг нь чанарын баталгаажуулалтаараа аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газраар ороод хариуг нь өгдөг.

Яг тийм дэлгэрэнгүй өөр тийм юм манайд их бага. Тодорхой сэдвүүд л ер нь голдуу байдаг.

Хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар бид Б.Пунсалмаа гишүүний санаачилж батлуулсан тогтоолтыг бид санал нэг байдаг. 2023, 2025 онд манай дээр хийгдээд, хийгдэхдээ манайх хийх ёсгүй ийм ажил л даа.

Тэгээд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос сэдэв баталж өгсөн учраас бид 2 жил хийсэн. Хийхдээ бид бараг худалч хүнд жил шахуу цаг зарцуулдаг. Одоо 1.4 их наяд, 1.3 их наядын төсөвтэй хоёр удаагийн юу орж

ирсэн. Бид нэмсэн төсвөөс дунджаар 70, 80 тэрбум төгрөг хоёр удаа л хасаж орж ирсэн байдаг юм билээ.

Тэгээд яг үүнтэй холбоотой нарийн мэдээллийг манай. 2026 онд Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Авто замын хөгжлийн төв гэсэн гурван хөгжлийн төв рүү орж үзэж байгаа.

Яагаад гэвэл магадлалаар яагаад замбараагүй юм нэмээд та нар ингэж магадлаад байгаа юм бэ гэдэг тэр учир шалтгаан руу нь орохгүй бол бид жил болгон төсөвт өртгийн нэмэгдэл хийгээд байвал энэ хэзээ ч зогсохгүй. Жил болгон бид нар дээр байгаа ажил бүх яам дээр байгаа ажил. Тэгээд Их Хурал дээр ирээд бас баахан ажил болдог ийм ажил байгаа учраас бид энэ учир шалтгаан руу нь сэдэв батлаад орсон явж байгаа.

Үүнийг намар Та бүхэнд тайлангаа тавиад танилцуулж байна. Бусад асуудлыг Д.Энхболд дарга.

О.Номинчимэг: 2 номерын микрофон.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар. Д.Энхболд.

Төсөвт өртгийн нэмэгдлийн аудитыг 2025 онд гүйцэтгэлийн аудит хийсэн.

Нийтдээ аудитаар 145 төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсөвт өртгийн нэмэгдэл, зардлыг хянаж, захиалагчаас ирүүлсэн 163.0 тэрбум төгрөг буюу 31 хувиар магадлалаар баталгаажуулсан төсвийн дүнг нь 87.9 тэрбумаар бууруулж аудитаар хянасан байгаа.

Энэ дээр нь нэмэлт ажлын тоо хэмжээг тодорхойлох, төсвийг тооцохдоо ажлын тоо хэмжээг давхардуулан тооцдог, материалын орц, нормыг үндэслэлгүйгээр нэмдэг гэх мэт олон асуудал байсан. Хамгийн их гаргаж байгаа шалтгаан дээр зураг, төсвийг буруу хийдэг. Зураг, төсвийг буруу хийсэн компаниудад нь хариуцлага тооцох ёстой гэдгийг Барилга, хот байгуулалтын сайд болон Барилгын хөгжлийн төвд нь албан шаардлага өгч зураг, төсвийн алдаа болон удаа дараа гаргасан компаниудын жагсаалтыг гаргаж хүргүүлсэн байгаа.

Тэгээд энэ жил бол энэ. Тогтолцоонд нь... /минут дуусав/

О.Номинчимэг: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: 2026 оны 6 сарын 29 буюу одоо ирэх нэг дэх өдрийн өглөөний 09.00 цагт Боловсролын зээлийн сангийн хөнгөлөлттэй зээлээр дэлхийн топ 100 сургуульд бакалавр, магистр, доктор болон хамтарсан хөтөлбөрт суралцах оюутны бүртгэлийн хугацаа дуусаж байгаа.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гадаадад суралцахад буцалтгүй тусламж олгох сонгон шалгаруулалт мөн яг дараагийн нэг дэх өдрийн 09.00 цагаас дэд бакалавр, бакалавр, магистр, докторт сурах сонгон шалгаруулалтын хугацаа нь ингээд дуусгаж байгаа.

Тэгэхээр үүнийг сонсож байгаа хүүхдүүд яаралтай материалаа цагт нь бүртгүүлж өгөөрэй.

2026 онд 172.0 тэрбум төгрөгийг Боловсролын зээлийн сан дээр төсөвлөж бид баталсан.

Өнөөдөр 2025 оны гүйцэтгэл ярьж байгаа. 2025 онд 157.0 тэрбум төгрөг. Тийм ээ.

Сонгон шалгаруулалт маань одоо ингээд явах гэж байна. Гэтэл хоёр долоо хоногийн өмнө билүү, Боловсролын сайд маань данс улайсан гээд яриад байгаа юм.

Тэгэхээр боловсон зээлийн сангаас хүн байна уу? Боловсролын зээлийн сангаас. Боловсролын зээлийн сангийн шинэ дарга байна.

Тэгэхээр энэ дээр тодорхой хариулмаар байна. Ямар сонгон шалгаруулалт одоо явах гэж байна? Дараагийн нэг дэхэд. Тийм ээ. Бэлэн үү? Сонгон шалгаруулалт дээр гардаг хэл ам гарахгүй биз дээ. Үүнийг бол маш олон аав, ээж нар, мөн цаашаагаа суралцахаар урилгаа авсан хүүхдүүд харж байгаа.

Ер нь хэдэн хүүхэд цаашаа явах ер нь боломж байгаа юм, бид нарт. 2025 оны 152.0 тэрбум төсөвлөөд эргэн төлөлт нь жоохон явсан. Гэхдээ түүгээр яг хэдэн хүүхэд яах вэ боломж нээгдсэн. Энэ жилийн эргэн төлөлт ер нь ямархуу явж байна? Энэ эргэн төлөгдөх нь үү, үгүй юу?

Мөн хажуугаар нь зөв шударгаар явсан олон хүүхдүүд бас энд хэлмэгдээд байгаа. Би ойлгож байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлуудыг хэрхэн цэгцлэх вэ? Одоо цэгцэлнэ гэж ярьсаар байгаад одоо энэ чинь ингээд гурав дахь жил рүүгээ бас орж байна л даа. Үүнийг нэг мөсөн цэгцэлмээр байна. Энэ асуудал хаанаа явна аа?

Дөрөвдүгээрт, цаашдаа Боловсролын зээлийн сан Боловсролын хөгжлийн сан болно гээд л Л.Энх-Амгалан сайд яриад байна л даа.

Яг юу гэсэн үг вэ? Үүнийг ер нь цаашдаа бие даасан институцийн хэмжээнд цаашаагаа авч явах шаардлага байна. Тэрийг бүгдээрээ харж байгаа.

Тэгэхээр энэ шинэчлэлийн хүрээнд ямар ажил хийгдэж байгаа юм? Энэ дөрвөн асуултад тодорхой хариулт аваад тодруулъя.

О.Номинчимэг: 4 номерын микрофон. П.Зохихсүрэн дарга.

П.Зохихсүрэн: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

2026-2027 оны хичээлийн жилд гадаадын их, дээд сургуульд, тэр дундаа дэлхийн шилдэг их сургуульд суралцахаар эрх авсан оюутнуудын хувьд Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр суралцах сонгон шалгаруулалт, нөгөөдөх нь гадаадын их, дээд сургуульд суралцахаар эрх авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд буцалтгүй тусламж үзүүлэх гэсэн ийм хоёр төрлийн сонгон шалгаруулалтын бүртгэл 5 сарын 30-нд эхэлсэн. 6 сарын 29-ний өглөө бүртгэл хаагдаад, 29, 30-ны өдрүүдэд сонгон шалгаруулалт зохион байгуулагдахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Мэдээж энд аль болохоор журмын дагуу шударга, ил тод зарчмын хүрээнд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад ажиллаж байгаа.

Энэ хүрээндээ Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Зээлийн эргэн төлөлт болон төсөвтэй холбоотой асуудал дээр хоёр дахь асуулт дээр тодруулъя.

Боловсролын зээлийн санд 2025 онд 157.0 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Гэвч оны сүүлээр төсвийн орлого бүрдээгүй шалтгаанаар 31.6 тэрбум төгрөгийг санхүүжилт олгоогүй ийм нөхцөл байдал үүссэн байна лээ.

Тэгэхээр энэ санхүүжилтийг олгоогүйгээс үүдэн зээлийн сан өртэйгөөр 2025 оноо ингээд тайлагнаад дууссан. 2026 онд нийтдээ 172.3 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Ингээд энэ 172.3 тэрбум төгрөгийнхөө 31.6-г 2025 оныхоо тэр дутуу олгогдсон санхүүжилтийг нөхөхөд зориулаад шууд хэрэглэсэн.

Тэгэхээр энэ маань нөгөө батлагдсан төлөвлөгөөнөөсөө дутах ийм асуудал үүссэнтэй холбоотойгоор энэ жилийн сонгон шалгаруулалтад явах гэж байгаа хүүхдүүдийн квот багассан асуудал байгаа.

Өөрөөр хэлбэл дэлхийн шилдэг их сургуульд бакалаврын хөтөлбөрт ноднин 74 квоттой байсан бол энэ жил бол аравхан квоттой байгаа.

Ер нь боломжийн тухайд гэх юм бол энэ жилийн хөтөлбөрөөр магистр докторын хөтөлбөрт нийтдээ 20 суралцагчийг, бакалаврт 10 суралцагчийг, 2 дээр нэмэх 2 хөтөлбөрөөр 2 суралцагчийг явуулахаар ийм квот батлагдсан байна.

Зээлийн эргэн төлөлтийн тухайд 2025 онд нийтдээ 30 тэрбум төгрөгийг эргэн төвлөрүүлнэ гэж төлөвлөсөн байсан.

Үүнээс 17.9 тэрбумыг төвлөрүүлсэн байна. 2025 оны байдлаар. 2026 оны байдлаар 145 тэрбумыг төвлөрүүл гэдэг төлөвлөгөөнд туссан байсан.

Гэхдээ энэ нь Боловсролын зээлийн сангаас өгсөн санал биш. Одоо ингээд холбогдох шатын байгууллагууд дээр хэлэлцэгдэх явцад 145.0 тэрбум төгрөгийн төлөвлөгөө тавигдсан байгаа. Яг одоо авлагын дүн гадаад зээл дээр нийтдээ 245.1 тэрбум төгрөгийн авлагатай бүртгэлтэй байгаа.

Гэвч энэ нь үнэн хэрэг дээрээ зарим нь гэрээ дүгнээгүйгээс үүдэлтэй яг бодит дүн бас биш байгаа. Нэг ёсондоо өнгөрсөн 30 жилийн турш гадаад зээлд зориулж байсан нийт зардлын хэмжээг оруулсан. Гэтэл 145 тэрбумыг эргэн төвлөрүүл гэдэг даалгавар өгч байгаа нь өөрөө бодитоор хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн байна гэж харж байгаа. Тухайлбал, Засгийн газрын 215 дугаар тогтоолд баталсан журмын дагуу зээлийн эргэн төлөлтийн графикийг 20 жилээр байгуулах ёстой.

Тэгэхээр энэ 245 тэрбум төгрөгийг 20 жилд хуваагаад үзэхэд бид бүх зээлдэгч нараа, бүх суралцагч нараа хариуцлагажуулаад зээлийг нь эргэн төлүүлэхэд энэ жил 12 тэрбумыг л гадаад зээлийн эргэн төлөлтөөс цуглуулах бодит эрх зүйн үндэстэй байдалтай байна гэсэн үг.

Одоогийн байдлаар 6 сарын 25-ны байдлаар 7.5 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэн ийм нөхцөл байдалтай байна. Гэхдээ тэр гадаадад суралцсан өнгөрсөн тэр... /минут дуусав/

О.Номинчимэг: 4 номер гүйцээж хариулъя.

П.Зохихсүрэн: 1997 оноос хойш гадаадад суралцагчдад зориулсан зээлийн хөтөлбөрөөр явсан гэрээ дүгнэгдээгүй 1255 суралцагчийн асуудал байна.

Тэгэхээр энэ 1255 суралцагчийн гэрээг дүгнэх, мөн гэрээг дүгнэсний дагуу та зээлээ эргэн төлнө үү гэсэн ийм албан мэдэгдлийг явуулах ажлыг хийхээр төлөвлөж байна.

Мөн гэрээ, эрх зүйн асуудлаар холбогдох асуудлуудыг нарийн нягталж тухайн цаг үед байгуулсан гэрээнийх нь үүргийн хэрэгжилтийг хангуулах хууль эрх зүйн хүрээнд зохицуулах ажлуудыг хийхээр бэлтгэл хангаж байна.

Цаашдаа тогтолцооны хувьд бид бүх л тогтолцоог нь харах юм бол Боловсролын зээлийн сан маань өөрөө хүмүүн капиталыг дэмждэг байгууллага гэхээсээ илүү –

- хэдэн хүнд зээл олгосон бэ,
- хэдэн хүнд тэтгэлэг олгосон бэ,
- хэдэн хүнд буцалтгүй тусламж олгосон

-гээд олгосон санхүүжилтийнхээ хэмжээгээр оюутныхаа тоогоор л ярьдаг.

Гэтэл бидэнд юу хэрэгтэй байгаа гэхээр хэдэн хүүхэд амжилттай сураад, хэдэн хүн улс, эх орондоо хэрэгтэй хүний нөөц болж өндөр чадварлаг мэргэжилтэн... /минут дуусав/

О.Номинчимэг: О.Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: 2025 онд 17.9 тэрбумын эргэн төлөлт. Энэ жил 7.5-тай л гэж ойлголоо.

Тэгэхээр татвар төлөгчдийн мөнгө зээл болоод очсон бол эргэн төлөгдөх ёстой юм.

Тэгэхээр Та хэлж байна шүү дээ. 1250 хүүхдийн гэрээ дүгнэгдээгүй байна. Энэ чинь дүгнэгдээгүй 20 жил болсон шүү дээ. Үүнийгээ дүгнэж дуусгах хэрэгтэй байна. Тэр 1250 дотор бас зөв яваад, зөв ажлаа хийгээд хаасан хүүхдүүд ч байгаа. Огт эргэн төлөөгүй хүмүүс ч байгаа.

Тэгэхээр үүнийгээ шийдэхгүй болохоор хэд нь эргэн төлөгдөх, төлөгдөхгүй нь одоо хүртэл ойлгомжгүй яваад байгаа юм.

Тэгээд үүнийгээ яаралтай дуусга.

Хоёрдугаарт, Та хэлж байна л даа. Нөгөө хүүхдүүд нь буцаж эргэж ирээд яг хэдэн жил хөдөлмөрлөсөн ч юм уу, энэ судалгаа чинь байдаггүй гээд. Харин наад судалгаагаа хийхгүй, тэр битгий хэл зээл өгчхөөд тэтгэлэг гээд ойлгуулаад явсан зөндөө хүүхдүүд гарч ирээд байна шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ цогцоор нь шинэчилмээр байгаа юм. Үүнийгээ цогцоор нь шинэчил. Тэгэхгүй бол жил болгоны асуудал чинь дуусахгүй байгаад байна. Тийм ээ.

О.Номинчимэг: 4 номер. Боловсролын зээлийн сан.

П.Зохихсүрэн: О.Батнайрамдал гишүүний хэлж байгаа саналыг ойлгож байна. Дэмжиж байна. Энэ бол хамгийн чухал асуудал.

Өөрөөр хэлбэл бид тогтолцооных нь хувьд энэ системээ харах юм бол зөвхөн орц нийлүүлэх биш. Тийм ээ. Энэ бодлогын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөө, үр дагаврыг тооцох. Тэгээд өгөгдөлд суурилсан системтэй дүгнэлтүүд гаргаж, аль бодлого маань ямар үр дүнтэй хэрэгжив ээ гэдгийг тооцох ёстой. Мөн төгсөгчдөө мөшгөх судалгаа хийдэг юм байхгүй байна.

Тэгэхээр үүнийг цаашид төрийн байгууллагуудын мэдээллийн уялдааг сайжруулах замаар үүнийг хийх боломжтой гэж харж байгаа.

Ингэснээрээ тухайн төгсөгч маань улсдаа ажиллаж байна уу, төрийн албанд ажиллаж байна уу, бизнесийн салбарт ажиллаж байна уу гэх мэтчилэн мөшгөх тогтолцоог сайжруулах. Нөгөө талаараа хариуцлагыг өндөржүүлэх тогтолцооны шинэчлэлүүдийг хийх. Мөн эрсдэлийн удирдлагын менежментийг энэ байгууллагын түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. Боловсролын зээлийн сан маань яг хүмүүн капиталд хөрөнгө оруулдаг байгууллагынхаа... /минут дуусав/

О.Номинчимэг: О.Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Тэгээд намар таны хэлж байсан тэр дүгнэсэн үү, үгүй юу гээд буцаад асууна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр үүнийгээ энэ зундаа яаралтай хийж дуусгах хэрэгтэй. Энэ дээр чинь хангалттай ажлын хэсэг гарсан. Тэгээд тэрнээс яг бодитой үр дүн одоохондоо харагдахгүй л байгаад байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, дараагийн долоо хоног явах сонгон шалгаруулалт ил тод явах хэрэгтэй байна. Яагаад гэвэл оролцож байгаа хүүхэд болгоны ард нь захыг нь мушгиад сууж байдаг аав, ээж нар байдаг байхгүй юу. Гадна нь бүгд ингээд хараад сууж байгаа.

Тэгэхээр аав, ээж нарт нь маш ойлгомжтой, ил тод, шударга явуулмаар байна. Дахиад хэл ам татлуулаад баймааргүй байна. Хүнээс хамааралгүй болгодог сонгон шалгаруулалтын юу руу орсон шүү дээ. Тийм ээ. Хүнээс хамаардаггүй. Хэн нэгэн даргын үүдэн дээр очиж сахидаггүй.

Тэгэхээр үүнийгээ улам сайжруулаад дараагийн долоо хоногийн сонгон шалгаруулалтаа хэл амгүй явуулаарай. Гэхдээ одоо төсвийн байдлаасаа болоод 10-хан квоттой л болж таарч байх шиг байна.

Тэгээд эргэн төлөлт ирэхгүй болохоор чинь квот чинь улам л багасна шүү дээ. Тийм ээ. Үүнийгээ цогцоор нь шийдээрэй.

Дараагийн долоо хоногт тэгээд энэ дээр бас... /минут дуусав/

О.Номинчимэг: Тийм байна. О.Батнайрамдал гишүүн үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүд нэрээ бүртгүүлнэ үү? Алга байна.

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

Байнгын хорооны дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн хэн байна? Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна.

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 57 минут үргэлжилж, 16 цаг 58 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД